



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 152

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 “г”, 3.2.6 “в” заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өндөршил сумын Дунд сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2'836'684 /хоёр сая найман зуун гучин зургаан мянга зургаан зуун наян дөрөв/ төгрөгийн анхны өртөгтэй, 2'269'347 /хоёр сая хоёр зуун жаран есөн мянга гурван зуун дөчин долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй бие засах газрын барилгыг актлан данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, ашиглаж болох эд зүйлд үнэлгээ тогтоон, эргэлтийн хөрөнгөд бүртгэж ашиглахыг Өндөршил сумын Дунд сургуулийн захирал Н.Дэлгэрсайханд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100331